



“СҮЛД-АУДИТ” ХХК

**ХАРААТ БУС АУДИТОРЫН
ТАЙЛАН**

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК

***2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар
болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан***

Улаанбаатар хот

2025 он



**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараахь хаягаар
харилцана уу:**

"СҮЛД-АУДИТ" ХХК

Хаяг: Монгол улс,
Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Бага
тойруу 8-р хороо, 11-р
хороолол GB center 502 тоот

Утас: 70118016

Web: www.suld-audit.mn

Захирал: Ч.Гүндбаяр

Утас: 99114056

e-mail: info@suld-audit.mn

Аудиторууд:

Ч. Гүндбаяр

Г. Баяржаргал

С. Лхагважав

Б. Долгорсүрэн

**УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

**АУДИТЫН ДУУСГАВАР БОЛГОСОН
ТУХАЙ ТАЙЛАН**

АГУУЛГА	ХУУДАС
1. Байгууллагын талаарх мэдээлэл	1
2. Удирдлагын хариуцлагын захидал	2
3. Хараат бус аудиторын тайлангийн дүгнэлт	3
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
5. Удирдлагад хүргэх захидал	9
6. Аудиторын тайлангийн тодруулга	10
7. Санхүүгийн тайлангийн тодруулга	16

2025 оны 03 дугаар сарын 10

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХУВЬЦААТ КОМПАНИ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Байгуулах шийдвэр:

УИД ХК нь анх 1924 онд Зөвлөлт Холбоот Улс (тэр үеийн нэршлээр)-ын тусламжтайгаар “Төв дэлгүүр” нэртэй үүсгэн байгуулагджээ. Улмаар Их Дэлгүүр нь 1961 онд одоогийн байршил буюу Энх тайвны өргөн чөлөөнд 150.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай шинэ барилга ашиглалтанд орсноор шилжин ирж, УИД гэж нэрлэгдэх болсон байна. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 1999 онд УИД-ийг хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулснаар “Компанийн тухай” хууль, бусад хууль тогтоомжийн дагуу хувьцаа эзэмшигчдээс оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь Монголын хөрөнгийн биржээр нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, нээлттэй хувьцаат компани болсон байна.

Үндсэн үйл ажиллагаа:

Гадаад худалдаа
Хүнсний болон барааны бөөний болон жижиглэнгийн худалдаа
Цайны болон түргэн хоолны газар
Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа

Гүйцэтгэх захирал:

Х.Эрдэнэбаатар

**Ерөнхий нягтлан
бодогч:**

Д. Чимгээ

Байнгын хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн
өргөн чөлөө, 67/1 5 давхар
Утас: 976-7577 9999

Өмнөх Аудит:

“СҮЛД-АУДИТ” ХХК
Улаанбаатар хот, Монгол улс
Сүхбаатар дүүрэг 8-р хороо
11-р хороолол, Бага тойруу
Жи-Би центр 502 тоот
Утас: 976-7011 8016
И-мэйл: info@suld-audit.mn

Аудитын компани:

“СҮЛД-АУДИТ” ХХК
Улаанбаатар хот, Монгол улс
Сүхбаатар дүүрэг 8-р хороо
11-р хороолол, Бага тойруу
Жи-Би центр 502 тоот
Утас: 976-7011 8016
И-мэйл: info@suld-audit.mn



СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2025.03.10 № 25111
танай _____ -ны № _____

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлан

Өөрчлөлтгүй дүгнэлт

Бид “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох заавар, журмын дагуу бүх материаллаг зүйлсийг хамруулан үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал, /МНБ/



Ч.Гүндбаяр
Ч.ГҮНДБАЯР

2025 оны 02 дугаар
сарын 03-ны өдөр

№: 4-3/19

Улаанбаатар
хот

"СҮЛД-АУДИТ" ХХК-д

Санхүүгийн тайлангийн талаарх
удирдлагын мэдэгдэл хүргүүлэх тухай

Бид "Улсын их дэлгүүр" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгын бүх материаллаг үзүүлэлтүүдээр СТОУС болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бэлтгэн толилуулсан болохыг үүгээр баталж байна.

Мөн санхүүгийн тайлантай холбоотой дараах үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Үүнд:

- Компанийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлж, санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэж, толилуулах;
- Нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөтлөх;
- Тайлант хугацааны санхүүгийн тайланд компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг бүрэн бүртгэж тусгах;
- Тайланд тусгагдсан хөрөнгө, түүний эх үүсвэрийг компанийн өмчлөлд бүрэн бүртгэх ба орхигдуулахгүй байх;

Хүндэтгэсэн,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЭРДЭНЭБААТАР


АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

Д.ЧИМГЭЭ

УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2023	/төгрөгөөр/ 12/31/2024
А.ХӨРӨНГӨ			
1.Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1	234,811.20	47,671,547.23
Дансны авлага	2	-	390,000.00
Татвар, НДШ-ийн авлага	2	704,282,423.28	17,386,424.31
Бусад авлага	2	-	-
Бараа материал	3	132,244,595.48	29,441,628.47
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	4	9,464,568.52	63,846,903.22
Эргэлтийн хөрөнгийн дүн		846,226,398.48	158,736,503.23
2.Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	5	14,315,710,599.92	13,317,022,054.90
Биет бус хөрөнгө		-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6	33,811,920.00	33,811,920.00
Хойшлогдсон татварын хөрөнгө	7	-	18,897,260.27
Бусад эргэлтийн бус хөрөнгө	8	-	558,560,700.64
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		14,349,522,519.92	13,928,291,935.81
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		15,195,748,918.40	14,087,028,439.04
Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
1.Өр төлбөр			
Дансны өглөг	9	256,067,835.10	928,554,331.13
Цалингийн өглөг	10	3,656,126.23	6,671,477.19
Татварын өр	10	51,435,912.63	5,595,409.32
НДШ-ийн өглөг	10	14,152.42	220,396.62
Хүүний өглөг	11	114,657,534.25	188,972,602.75
Ногдол ашгийн өглөг	11	15,433,581.00	15,433,581.00
Урьдчилж орсон орлого	12	150,000,000.00	-
Бусад богино хугацаат өр төлбөр	11	960,674.13	946,675.63
Богино хугацаат өр төлбөрийн дүн		592,225,815.76	1,146,394,473.64
Урт хугацаат зээл	10	17,000,000,000.00	17,000,000,000.00
Хойшлогдсон татварын өр		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		17,000,000,000.00	17,000,000,000.00
Өр төлбөрийн нийт дүн		17,592,202,852.42	18,146,394,473.64
2.Эздийн өмч			
а.Төрийн			
б.Хувийн			
в. Хувьцаат	13	3,680,785,000.00	3,680,785,000.00
Халаасны хувьцаа	13	(175,964,106.00)	(175,964,106.00)
Нэмж төлөгдсөн капитал	13	133,351,798.00	133,351,798.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14	1,600,084,101.82	1,600,084,101.82
Эздийн өмчийн бусад хэсэг		-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	15	(7,634,733,691.18)	(9,297,622,828.42)
Эздийн өмчийн дүн		(2,396,476,897.36)	(4,059,366,034.60)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		15,195,748,918.40	14,087,028,439.04

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	/төгрөгөөр/	
		12/31/2023	12/31/2024
Борлуулалтын орлого (цэвэр)	16	8,310,638,334.26	11,038,785,569.00
Борлуулалтын өртөг		-	-
Нийт ашиг /алдагдал/		8,310,638,334.26	11,038,785,569.00
Түрээсийн орлого		-	-
Хүүгийн орлого	17	-	2,880,143.35
Ногдол ашгийн орлого		-	-
Эрхийн шимтгэлийн орлого		-	-
Бусад орлого	17	-	300,001.00
Борлуулалт, маркетингийн зардал	18	4,554,860.04	5,364,870.20
Ерөнхий ба удирдлагын зардал	18	5,469,870,812.08	5,582,092,641.64
Санхүүгийн зардал	19	1,679,958,904.13	2,111,575,342.47
Бусад зардал	18	17,775,586.58	99,208.82
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-	-
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		-	-
Бусад ашиг (алдагдал)	20	(1,031,900,885.00)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		106,577,286.43	3,342,833,650.22
Орлогын татварын зардал	21	-	(18,609,245.93)
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)		106,577,286.43	3,361,442,896.15
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		106,577,286.43	3,361,442,896.15
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-	-
Бусад олз (гарз)		-	-
Орлогын нийт дүн		106,577,286.43	3,361,442,896.15
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

<u>Үзүүлэлт</u>	<u>Өмч</u>	<u>Халаасны хувьцаа</u>	<u>Нэмж төлөгдсөн капитал</u>	<u>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл</u>	<u>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</u>	<u>Нийт дүн</u>
2023 оны 12-р сарын 31-ний өдөр	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(7,634,733,691.18)	(2,396,476,897.36)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(7,634,733,691.18)	(2,396,476,897.36)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга) Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(5,024,332,033.39)	(5,024,332,033.39)
Өмчид гарсан өөрчлөлт					3,361,442,896.15	3,361,442,896.15
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
2024 оны 12-р сарын 31-ний өдөр	3,680,785,000.00	(175,964,106.00)	133,351,798.00	1,600,084,101.82	(9,297,622,828.42)	(4,059,366,034.60)

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК
АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2023	12/31/2024
<i>/төгрөгөөр/</i>		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	10,889,542,745.20	31,661,700,823.58
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	10,266,760,800.00	12,459,425,880.00
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Бусад мөнгөн орлого	622,781,945.20	19,202,274,943.58
Мөнгөн зарлагын дүн (-)	10,644,494,556.64	31,398,021,118.14
Ажиллагчдад төлсөн	97,659,489.23	130,361,032.35
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	22,792,520.00	18,549,573.94
Ашиглалтын зардалд төлсөн	3,788,303,438.54	3,814,287,040.03
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	4,421,099,900.24	108,303,574.62
Хүүний төлбөрт төлсөн	1,679,958,904.13	2,037,260,273.97
Татварын байгууллагад төлсөн	434,918,535.50	839,544,209.23
Даатгалын төлбөрт төлсөн	186,000,000.00	186,000,000.00
Бусад мөнгөн зарлага	13,761,769.00	24,263,715,414.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	245,048,188.56	263,679,705.44
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	249,933,511.50	219,123,112.76
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	249,933,511.50	219,123,112.76
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(249,933,511.50)	(219,123,112.76)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	10,002,880,143.35
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	10,000,000,000.00
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	2,880,143.35
Мөнгөн зарлагын дүн (-)	-	10,000,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	10,000,000,000.00
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	2,880,143.35
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(4,885,322.94)	47,436,736.03
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	<i>5,120,134.14</i>	<i>234,811.20</i>
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	<i>234,811.20</i>	<i>47,671,547.23</i>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ**УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК-ИЙН
УДИРДЛАГАД**


“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарал татсан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг энэхүү тайланд багтаасан болно.

Санхүүгийн тайлангийн аудитыг Аудитын Олон Улсын Стандарт болон аудитын горимын дагуу хийж гүйцэтгэх явцад бидний анхаарал татсан тодорхой зүйлүүдийг удирдлагад хүргэх зорилгоор аудитын тайланг толилуулав.

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан болно. Санхүүгийн тайланд аудит хийх явцад ажиглагдсан бидний өгсөн зөвлөмжийг анхаарч, хүлээн авч, хэрэгжүүлж ажиллана гэдэгт итгэж байна. Түүнчлэн тайланд бичигдсэн зөвлөмжийн талаар ярилцах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажилд туслахад бэлэн байх болно.

Аудитын ажлын явцад бидэнтэй хамтран ажиллаж, туслалцаа үзүүлж байсан “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархлаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх захирал


Ч. Гүндбаяр МНБ

“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХУВЬЦААТ КОМПАНИ

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, ТЭМДЭГЛЭЛ

1. Үйл ажиллагаа ба зохион байгуулалт

Үйл ажиллагаа:

Улсын Их Дэлгүүр нь дэлхийн шилдэг брэндүүдийн цахилгаан бараа, гэр ахуйн бараа, гоо сайхны бүтээгдэхүүн, эрэгтэй эмэгтэй хүүхдийн брэнд хувцас, гутал цүнх зэргийг худалдаалахаас гадна банк санхүү, даатгал, зээлийн үйлчилгээ, АТМ, ТҮЦ машин, цэцэг бэлэг дурсгалын үйлчилгээ, кино театр, хүүхдэд зориулсан үйлчилгээний төвүүд, хоолны газрууд, олон нийтэд нээлттэй түүхэн булан болон хүнс барааны супермаркет гээд бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэг дор төвлөрүүлсэн, дэлхийн жишигт хүрсэн “Олон жилийн баялаг түүхтэй орчин үеийн хэв шинж бүхий Монголын хамгийн том худалдааны төв” бөгөөд түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Улсын Их Дэлгүүр нь тус бүр 140 хүний багтаамжтай 2 танхим бүхий сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий кино театрттай үйл ажиллагаагаа явуулж байна.

Ажиллагсадын тоо

2024 оны 12 дугаар сарын байдлаарх нийгмийн даатгалын тайланд тайлагнаснаар нийт 4 ажилтантай байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл:

№	Овог нэр	Гишүүнчлэл
1	Янсанжав Наваан	ТУЗ-ийн дарга
2	Алтангэрэл Норсмаа	ТУЗ-ийн гишүүн
3	Идэштогтох Галбуян	ТУЗ-ийн гишүүн
4	Тэрбиш Сарантуяа	ТУЗ-ийн гишүүн
5	Хүрэлхүү Эрдэнэбаатар	ТУЗ-ийн гишүүн
6	Төрөө Амартөр	ТУЗ-ийн гишүүн
7	Мөнхнасан Дамирансүрэн	Хараат бус ТУЗ-ийн гишүүн
8	Нанзаддорж Энхчимэг	Хараат бус ТУЗ-ийн гишүүн
9	Мэнхсоо Ганцэцэг	Хараат бус ТУЗ-ийн гишүүн

Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн удирдлагын бүтэц зохион байгуулалт:



2. Санхүүгийн тайлагналын зарчим

Нягтлан Бодох Бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалын дагуу батлан 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн санхүү бүртгэл тайлагналд мөрдлөг болгон ажиллаж байна. Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримталдаг.

а/ Тайлан бэлтгэсэн үндэслэл

✓ Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий суурь

Тус байгууллагын санхүүгийн тайлангууд нь нягтлан бодох бүртгэлийг аккрузал суурьд үндэслэн, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) болон Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн Сангийн яамнаас батлан гаргасан заавар журам, бусад холбогдох хууль тогтоомж аргачлалын дагуу бэлтгэсэн байна. Компанийн тайлагнах валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлэгдэж, төгрөгөөр харуулж тайлагнагдсан.

✓ Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн. Тасралтгүй үйл ажиллагааны зарчмын төсөөлөл хүчинтэй байх эсэх нь компани ирээдүйд тасралтгүй үйл ажиллагаагаа хадгалж чадах эсэхээс хамаарна.

б/ Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ. Тэдгээрт гарсан мөнгөн хөрөнгийн гүйлгээг тус тусад нь мөнгөн хөрөнгийн журналд тусгадаг байна.

г/ Авлага

Авлагыг урьдчилан тооцоолсон боломжит үнэ цэнээр нь бүртгэлд тусгадаг. Зээлээр худалдсан бараа бүтээгдэхүүн болон үзүүлсэн ажил үйлчилгээнийхээ төлбөрийг худалдан авагч, бусад харилцагч этгээдээс нэхэмжилж авах мөнгөн дүнг авлагаар тооцож бүртгэдэг. Худалдан авагчиддаа борлуулалтын хөнгөлөлт үзүүлэх үед борлуулалтын хөнгөлөлтийг нийт дүнгийн аргаар бүртгэдэг.

Гадаад валютаар үүссэн авлагыг гүйлгээ гарсан өдөр мөрдөж буй Монгол банкны албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэлд тусгадаг. Төлбөр хүлээн авсан валютын зарласан ханш нь гүйлгээ гарсан өдрийн ханшнаас хэлбэлзсэн хэмжээгээр ханшийн зөрүү бүртгэдэг байна.

НБББББ-т найдваргүй авлагыг данснаас хасахдаа удирдлагын шийдвэрийг үндэслэн данснаас хасна гэж заасан. Найдваргүй гэж тооцох хувь хэмжээг тодорхойлохдоо өмнөх жилүүдийн найдваргүй авлагын зардлын дүнд үндэслэн тогтоодог байна.

д/ Бараа материал

Тус байгууллага нь бараа материалын бүртгэлийн байнгын системийг ашигладаг ба үүний дагуу бараа материалыг худалдаж авсан тухай бүр нь орлого авч, зарлагадах тухай бүр өртөг, зардалд бүртгэдэг байна.

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар үнэлдэг. Бараа материалын өртгийг эхэлж авсаныг эхэлж зарлагдах (ЭАЭЗ) аргыг ашигладаг бөгөөд бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд авч ирэхтэй холбогдон гарсан зардал ордог.

Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг борлуулахтай холбоотой гарах зардал болон иж бүрдэл болохтой холбоотой тооцоолсон зардлыг хассан дүн юм.

е/ Урьдчилж төлсөн зардал/ тооцоо

Үйл ажиллагааны зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрөх хүртэл урьдчилж төлсөн зардлаар тайлагнадаг. Урьдчилж төлсөн зардлыг төлсөн хэмжээгээр буюу нэрлэсэн үнээр илэрхийлнэ.

в/ Үндсэн хөрөнгө ба түүний элэгдэл

i. Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болгохтой холбоотой гарсан бусад зардал, мөн хөрөнгийн зүйлсийг барьж байгуулах газар дээрх зүйлсийг нураах, зайлуулах, газрыг сэргээх зэрэг өртгүүд багтдаг.

ii. Үндсэн хөрөнгийн солилцоо

Үндсэн хөрөнгийг хооронд нь солилцох гүйлгээг Нягтлан бодох бүртгэлд тусгахдаа өгч байгаа болон авч байгаа хөрөнгийн аль тодорхой байгаа зах зээлийн үнэ дээр үндэслэдэг байна. Өөр төрлийн хөрөнгийг солилцож буй үед олз, гарзын аль алинийг нь хүлээн зөвшөөрдөг бол ижил төрлийн хөрөнгө солилцож буй үед зөвхөн гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг байна.

Элэгдэл

Элэгдлийг хөрөнгө түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглагдах жилийнх нь туршид шулуун шугамын аргаар элэгдүүлж, ашиг, алдагдлаар бүртгэдэг. Худалдаж авсан үндсэн хөрөнгийг түүнийг байршуулж, ашиглахад бэлэн болсон үеэс нь дотооддоо барьж байгуулсан хөрөнгийн хувьд тэдгээрийг дуусгавар болгож, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон үеэс нь эхлэн элэгдэл байгуулдаг. НББ-ийн бодлогын баримт бичигт өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлж тусгаагүй. Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн ангилал	Ашиглалтын хугацаа (жилээр)
Барилга байгууламж	25 жил
Машин тоног төхөөрөмж	10 жил
Тавилга эд хогшил	10 жил
Компьютер дагалдах хэрэгсэл	2 жил
Бусад үндсэн хөрөнгө	10 жил

ж/ Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтад эргэлтийн бус өмчийн үнэт цаас, хараат компанийн энгийн хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт, бонд барьцаалал, өрийн бичиг зэрэг өрийн хэрэгслийн хөрөнгө оруулалт, бонд эргэлтээс гарах, хувьцаа худалдан авах зэрэг бусад зорилго бүхий сан, үнэ цэнийг өсгөх зорилгоор эзэмшиж байгаа үндсэн

хөрөнгө, нэгдсэн компанид олгосон урьдчилгаа, нөхөрлөл болон хамтарсан үйлдвэрт оруулсан өмч, зээл ба эд хөрөнгийн хувь оролцоо гэх мэт төрөл бүрийн бусад хөрөнгө оруулалт багтана.

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг ихэвчлэн олж бэлтгэсэн өртгөөр нь дансанд бүртгэдэг. Урт хугацаат хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэ цэнэ буурч байгаа тохиолдолд үнийн бууралтыг хөрөнгө оруулалт тус бүрээр тодорхойлж, санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч тусгадаг.

з/ Дансны болон бусад өглөг

Өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бусдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага бөгөөд ирээдүйд төлөх бодит өртгөөрөө бүртгэлд тусгагддаг. Өр төлбөрийг богино хугацаат болон урт хугацаат өр төлбөр гэж ангилан балансад тусгана. Зээлээр худалдан авсан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнийхээ төлбөрийг борлуулагч тал болон бусад харилцагч этгээдэд төлөх мөнгөн дүнг өглөгөөр тооцож бүртгэлд тусгадаг байна.

“Улсын Их Дэлгүүр” ХК нь тасралтгүй давтагдаж байдаг барилгын урсгал засвар мөн бүх төрлийн инженерийн хяналт болон хөдөлмөрийн аюулгүй байдал, программ хангамж, цэвэрлэгээ, харуул хамгаалалтын үйлчилгээг харилцагч байгууллагуудаас авдаг. Гэрээний дагуу үзүүлсэн энэхүү ажил үйлчилгээний төлбөрийг хэдий хугацаанд ямар хэлбэрээр төлөхийг гэрээнд тодорхой тусгаж, хугацаандаа хийгдээгүй ажил үйлчилгээний үнийн дүнд хүү болон алданги ногдуулахаар гэрээнд зааж, түүнийг төлбөрийн нэхэмжлэл баримтанд бичиж, улирал бүр тооцоо нийлэн баталгаажуулна

и/ Хувьцаат капитал

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн энгийн хувьцаа нь хуваагдахгүй бөгөөд хувьцаа тус бүр 1 /нэг/ саналын эрхтэй байна. Энгийн хувьцааг эздийн өмчид ангилдаг. Шинээр хувьцаа гаргахад шууд хувиарилагдах зардлыг хувьцаа гарган борлуулсаны орлогоос хасаж тооцдог. Гаргасан нэгж хувьцааны үнэд хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнийн илүүдлийг нэмж төлсөн капиталын өсөлтөөр хүлээн зөвшөөрдөг.

“Улсын Их Дэлгүүр” ХК нь нийтэд нээлттэй хувьцаат компани учраас хөрөнгө, өр төлбөрт нөлөөлөхгүй өмчийн өөрчлөлт буюу хувьцааны жижигрүүлэлт, хувьцаагаар ногдол ашиг тараах, давуу эрхтэй хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх зэрэг хувьцаатай холбоотой өмчийн өөрчлөлтийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, гаргасан шийдвэрийг үндэслэн тайланд тусгадаг байна.

й/ Халаасны хувьцаа

“Улсын Их Дэлгүүр” ХК нь Халаасны хувьцааны худалдан авалтыг бүртгэх өртгийн аргыг ашиглана. Халаасны хувьцааны худалдан авалтыг худалдан авсан өдрийн өртөг дээр суурилан бүртгэнэ.

к/ Орлогыг хүлээн зөвшөөрөх

Бараа, үйлчилгээг мөнгөөр эсвэл мөнгө нэхэмжлэх эрх буюу авлагаар арилжсан үед, мөнгө эсвэл мөнгө нэхэмжлэх эрхийн тогтоосон дүнд шууд хөрвөх боломжтой хөрөнгийг арилжаагаар хүлээн авсан бол орлого хэрэгжих боломжтой гэсэн зарчмаар бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчдад хүлээлгэн өгсөнөөр, ажил үйлчилгээний орлогыг аккрэул суурьт үндэслэн тайлант хугацааны туршид хуримтлуулан, хэрэглэгчдэд ажил үйлчилгээ үзүүлж, бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчдад шилжүүлж нэхэмжлэх боломжтой болсон үед орлогоор хүлээн зөвшөөрдөг байна. Орлого нь НӨАТ болон бусад татвар хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр бодит үнэ цэнээр хэмжигддэг.

Хүү, түрээсийн орлого нь байгууллагын хөрөнгийг бусад этгээд ашиглахыг зөвшөөрсөний дүнд бий болсон орлогыг өнгөрсөн хугацаа буюу хөрөнгө ашиглалтаар хүлээн зөвшөөрдөг байна. Мөн үнэ төлбөргүй, хандиваар хүлээн авсан бараа бүтээгдэхүүнийг орлогоор хүлээн зөвшөөрдөг байна.

л/ Өртөг/ Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

м/ Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал

Бүтээгдэхүүн ажил үйлчилгээний өртөгт хамаарахгүй, үйл ажиллагааны явцад гардаг ерөнхий удирдлагын зардлыг зардлын ангиллаар бүртгэнэ. Энэ бүртгэл нь үйл ажиллагаанд ямар төрлийн зардал хэдий хэмжээгээр гарсныг тодорхойлохоос гадна хяналт тавихад чухал ач холбогдолтой байна.

н/ Санхүүгийн зардал

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардал, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын хасагдуулгаас бүрдэнэ. Хөрөнгийг ашиглах зориулалтаар нь бэлэн болгоход хугацаа шаарддаг хөрөнгийн бүтээн босголт, өргөтгөл, шинэчлэлд хамаарах зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулдаг. Бусад бүх зээлийн өртгийг гарсан тайлант хугацааны зардлаар бүртгэдэг.

о/ Орлогын албан татварын бүртгэл

Татварын зардал нь тайлант жилийн болон хойшлуулсан татварын зардлын нийлбэрээс бүрдэх бөгөөд орлогын тайланд тусгагддаг. Компанийн татвар нь тайлант жилийн татвар ногдуулах орлогод ногдох балансын өдрөөр хүчинтэй байгаа татварын хувь хэмжээгээр тооцсон бөгөөд өмнөх үеийн татварын өглөг, хойшлуулсан татварын хөрөнгө ба өр төлбөрийг тохируулсан хүлээгдэж буй татварын хөрөнгө эсвэл өглөг байна.

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог. Ирээдүйд татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрт хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

ө/ Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ба уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

п/ Холбоотой талуудын тодруулга

НББОУС 24 Холбоотой талуудын тодруулгад заасны дагуу толгой компанийн нэр, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь ялгаатай бол тэрхүү хяналт тавигч компани, хувь хүний нэрийг, тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд олгосон урт болон богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, ажлаас халагдсаны тэтгэмж, хувьцаанд суурилсан төлбөр, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг тодруулна.

(i) Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотнын гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэрүүлэх удирдлагын гишүүн бол.

(ii) Дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группын бүрэлдэхүүнд багтаж байвал (өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид хамаардаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой);
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол (эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан группын нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол);
- Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь компани эсвэл түүнтэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжид зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж (эсвэл түүний толгой компани)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.
- Компани эсвэл компанийн толгой компанид менежментийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж эсвэл группын гишүүн аж ахуй нэгж бол.

Эдгээр тэмдэглэлүүд нь хавсаргасан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.



**“УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

1. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Улсын Их Дэлгүүр ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаархи мөнгөн хөрөнгө дараах байдалтай байна.

Дансны нэр	Дансны дугаар	Валют	/мянган төгрөг/	
			2023.12.31	2024.12.31
Харилцах – Голомт банк	2735100290	Төгрөг	99.3	47,419.5
Харилцах – Хаан банк	5040345952	Төгрөг	101.5	230.1
Харилцах – Хөрөнгийн бирж	29602021	Төгрөг	0.0	0.0
Харилцах – ХХБ	415090310	Төгрөг	34.0	22.0
Бэлэн бус мөнгөний дүн			234.8	47,671.5
Нийт дүн			234.8	47,671.5

Голомт, Хаан, Худалдаа хөгжлийн болон Хөрөнгийн биржийн харилцахын дансдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Санхүү байдлын тайлангийн үлдэгдлийг гүйлгээ балансын үлдэгдэл болон харилцагч банкны үлдэгдлийн баталгаатай тулган баталгаажуулахад 47,671.5 мянган төгрөгөөр таарч байна.

2. ДАНСНЫ АВЛАГА

а. Дансны авлага

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Дотоодын бэлтгэн нийүүлэгчдээс авах авлага	10,600.8	10,600.8
Худалдан авагчдаас авах авлага	11,248.8	11,248.8
Найдваргүй авлагын нөөц	(21,849.6)	(21,849.6)
Нийт дүн	-	-


Тус байгууллага нь 21,849.6 мянган төгрөгийн авлагыг найдваргүй авлагын нөөц байгуулсан байна.

б. Татвар, НДШ-ийн авлага

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
НӨАТ-ын авлага /Барилга/	481,416.7	-
НӨАТ-ын авлага /Тоног төхөөрөмж/	205,981.5	-
Хойшлогдсон НӨАТ-ын авлага	2,636.5	3,142.8
ХХОАТ-ын авлага	3.9	-
ААНОАТ-ын авлага	14,243.6	14,243.6
Нийт дүн	704,282.2	17,386.4

в. Бусад авлага

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Холбоотой талаас авах авлага групп	-	390.0
Нийт дүн	-	390.0



3. БАРАА МАТЕРИАЛ

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Хангамжийн материал	132,244.6	29,441.6
Нийт дүн	132,244.6	29,441.6

Тайлант хугацаанд хангамжийн материал нь 48,392.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 151,195.6 мянган төгрөгөөр буурсан нь гэрэлтүүлэг болон бусад материалууд байна.

4. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Урьдчилж гарсан зардал /даатгал/	3,966.7	63,846.9
Урьдчилж төлсөн тооцоо	5,497.9	-
Нийт дүн	9,464.6	63,846.9

Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл 63,846.9 мянган төгрөг нь №24082020857 дугаартай байгууллагын хариуцлагын даатгалын гэрээний төлбөр 4,679.6 мянган төгрөг, №24122081723 дугаартай Үл хөдлөх хөрөнгийн даатгалын гэрээний төлбөр 59,167.3 мянган төгрөг байна.

5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Дансны нэр	/мянган төгрөг/			
	2023.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2024.12.31
Үндсэн хөрөнгө				
1 Барилга, байгууламж	18,469,607.5	-	-	18,469,607.5
2 Машин, тоног төхөөрөмж	4,855,796.7	219,123.1	28,832.7	5,046,087.1
3 Тавилга эд хогшил	80,276.3	-	45,590.6	34,685.7
4 Компьютер, бусад хэрэгсэл	29,510.8	1,090.9	18,374.0	12,227.7
Нийт дүн	23,435,191.3	220,214.0	92,797.3	23,562,608.0
Хуримтлагдсан элэгдэл				
1 Барилга, байгууламж	7,514,712.6	753,693.1	-	8,268,405.7
2 Машин, тоног төхөөрөмж	1,518,012.0	441,576.4	28,832.8	1,930,755.6
3 Тавилга эд хогшил	78,596.6	1,091.8	45,491.4	34,196.9
4 Компьютер, бусад хэрэгсэл	8,159.6	4,068.0	-	12,227.6
Нийт дүн	9,119,480.8	1,200,429.3	74,324.2	10,245,585.9
Үндсэн хөрөнгө /цэвэр дүн/	14,315,710.5			13,317,022.1

Улсын их дэлгүүрийн барилга нь үл хөдлөх эд хөрөнгийн 2202006240 тоот Улсын бүртгэлийн дугаартай 12,479 ам.метр талбайтай "А" хэсэг буюу 3,119,850.0 мянган төгрөгийн үнэлгээтэй, 2202006253 тоот Улсын бүртгэлийн дугаартай 9,787.8 ам.метр талбайтай "Б" хэсэг 1,467,010.0 мянган төгрөгийн үнэлгээтэй, 2202006254 тоот Улсын бүртгэлийн дугаартай 90 ам.метр талбайтай "Дэд станц" хэсэг 22,500.0 мянган төгрөгийн үнэлгээтэй, 2202018563 тоот Улсын бүртгэлийн дугаартай 4502 ам.метр талбайтай "Өргөтгөл" хэсэг 6,600,000.0 мянган төгрөг нийт 11,209,360.0 мянган төгрөгийн үнэлгээтэй, 26,858.8 ам.метр талбайгаас бүрдсэн барилгатай байна.



6. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Хөрөнгө оруулалт	33,811.9	33,811.9
Нийт дүн	33,811.9	33,811.9

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх урт хугацаат хөрөнгө оруулалт дансны 33,811.9 мянган төгрөг нь “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нэг бүр нь 933 төгрөгийн үнэ бүхий 36,240 ширхэг хувьцаа байна.

7. ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	18,897.3
Нийт дүн	-	18,897.3

Хаан болон Голомт банкны зээлийн хүүгийн өглөгөөс хойшлогдсон татварын хөрөнгө үүсгэсэн байна.

8. БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
НӨАТ-ын авлага /Барилга/	-	421,239.7
НӨАТ-ын авлага /Тоног төхөөрөмж/	-	137,321.0
Нийт дүн	-	558,560.7

9. ДАНСНЫ ӨГЛӨГ

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг	83,028.6	16,888.3
Дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг-барьцаа	45,575.1	51,013.8
Холбоотой талд өгөх өглөг Групп	127,424.5	860,652.2
Ажилчин албан хаагчдад өгөх өглөг	39.6	-
Нийт дүн	256,067.8	928,554.3

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх 928,554.3 мянган төгрөгийн өглөгөөс 860,652.2 мянган төгрөгийн өглөг нь холбоотой талд өгөх группийн өглөг ба нийт 875,460.3 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан байна.

10. ЦАЛИН БОЛОН НДШ, ТАТВАРЫН ӨГЛӨГ

а. Цалингийн өглөг

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Цалингийн өглөг	3,656.1	6,671.5
Нийт дүн	3,656.1	6,671.5

б. НДШ болон татварын өглөг

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
ХХОАТ-ын өглөг	-	251.7
НӨАТ-ын өглөг	51,435.9	5,070.2
Бусад татварын өглөг	-	273.4
ЭМД, НДШ-ийн өглөг	14.1	220.4
Нийт дүн	51,450.0	5,815.7

11. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Хүүний өглөг	114,657.5	188,972.6
Ногдол ашгийн өглөг	15,433.6	15,433.6
Бусад өглөг	960.6	946.7
Нийт дүн	131,051.7	205,352.9

Хаан болон Голомт банкны зээлийн хүүгийн өглөгийн 188,972.6 мянган төгрөг, ногдол ашгийн өглөг 15,433.6 мянган төгрөг нь 2015 онд үүссэн өглөг олон жил данс бүртгэлд бүртгэгдсээр байна.

12. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

а. Урт хугацаат зээл

Зээлдүүлэгч	Гэрээний дугаар	Зээлийн дүн	/мянган төгрөг/	
			2023.12.31	2024.12.31
Урт хугацаат зээл				
Хаан банк	ЗЭНГ18/39-3	10,000,000.0	10,000,000.0	10,000,000.0
Урт хугацаат зээлийн дүн			10,000,000.0	10,000,000.0
Голомт банк				7,000,000.0
Нийт урт хугацаат зээлийн дүн				17,000,000.0

б. Урьдчилж орсон орлого

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Номин Реалтор ХХК-ийн түрээсийн тооцоо	150,000.0	-
Нийт дүн	150,000.0	-

13. ХУВЬЦААТ КАПИТАЛ

а. Энгийн хувьцаа

Төрөл	/мянган төгрөг/			
	2024	2023	2024	2023
	Хувьцааны тоо /ширхэг/		Хувьцааны дүн	
Энгийн хувьцаа				
01 дүгээр сарын 01-ний өдөр	36,807,850	36,807,850	3,680,785.0	3,680,785.0
12 дугаар сарын 31-ний өдөр	36,807,850	36,807,850	3,680,785.0	3,680,785.0

Нийт энгийн хувьцааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 36,807,850 ширхэг хувьцаанаас бүрдэж байгаа бөгөөд хувьцааны 70.2 хувийг 5 иргэн, үлдэх 29.8 хувийг жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

б. Халаасны хувьцаа

Төрөл	/мянган төгрөг/			
	2024	2023	2024	2023
	Хувьцааны тоо /ширхэг/		Хувьцааны дүн	
Халаасны хувьцаа				
01 дүгээр сарын 01-ний өдөр	(1,683,139)	(1,683,139)	(175,964.1)	(175,964.1)
12 дугаар сарын 31-ний өдөр	(1,683,139)	(1,683,139)	(175,964.1)	(175,964.1)

УИД ХК нь нэг бүрийг 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 36,807,850 ширхэг, нийт 3,680,785.0 мянган төгрөгийн энгийн хувьцааг эргэлтэд гаргасан ба үүнээс 1,683,139 ширхэг хувьцааг нэг бүрийг нь дунджаар 104.54 төгрөгөөр худалдан авч халаасалсан ба 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 35,124,711 ширхэг хувьцаа эргэлтэнд байна.

в. Нэмж төлөгдсөн капитал

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Нэмж төлөгдсөн капитал	133,351.8	133,351.8
Нийт дүн	133,351.8	133,351.8

14. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,600,084.1	1,600,084.1
Нийт дүн	1,600,084.1	1,600,084.1

15. ХУРИМТЛАГДСАН АШИГ, (АЛДАГДАЛ)

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(7,741,310.9)	(12,659,065.7)
Нийт дүн	(7,741,310.9)	(12,659,065.7)

УИД ХК нь тайлант хугацаанд 3,361,442.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

16. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

УИД ХК-ийн борлуулалтын үндсэн орлого нь түрээсийн орлого байна.

Төрөл	/мянган төгрөг/			
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт	%
Түрээсийн орлого	8,115,228.0	8,926,750.8	811,522.8	10.0
Шүүхийн шийдвэрээр	800,000.0	2,400,000.0	1,600,000.0	300.0
Нийт орлогын дүн	8,915,228.0	11,326,750.8	2,411,522.8	27.0
Борлуулалтын хөнгөлөлт	604,589.7	287,965.3	(316,624.4)	(52.4)
Цэвэр нийт орлогын дүн	8,310,638.3	11,038,785.5	2,728,147.2	32.8

Тус байгууллага нь Номин Реалтор ХХК /Харилцан хамаарал бүхий/-д түрээсийн гэрээний дагуу нийт 26,858.8м² талбайг 2024 оны байдлаар сарын 818,285.5 мянган төгрөгөөр түрээслэн ажиллаж байна.

Тайлант онд борлуулалтын цэвэр орлого өмнөх оноос 811,522.8 мянган төгрөг букуу 10.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

17. БУСАД ОРЛОГО

а. Бусад орлого

Дансны нэр	/мянган төгрөг/	
	2023.12.31	2024.12.31
Хүүний орлого	-	2,880.1
Бусад орлого	-	300.0
Нийт дүн		3,180.1

18. БОРЛУУЛАЛТ БОЛОН ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ*а. Борлуулалт маркетингийн зардал*

Төрөл	/мянган төгрөг/	
	Тайлант он	Бүтэц
Зар сурталчилгаа – Сонин хэвлэл	581.1	10.8%
Зар сурталчилгаа – Телевиз	399.0	7.4%
Рекламны эх бэлтгэл	2,454.5	45.8%
PR, ивээн тэтгэлэгийн зардал	1,930.2	36.0%
Зардлын нийт дүн	5,364.8	100.0%

б. Ерөнхий удирдлагын зардал

Төрөл	/мянган төгрөг/	
	Тайлант он	Бүтэц %
Ажиллагчдын цалингийн зардал	144,553.1	2.60
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	9,818.9	0.18
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	184,696.1	3.33
Бичиг хэргийн зардал	973.8	0.02
Шуудан холбооны зардал	682.5	0.01
Мэргэжлийн үйлчилгээний зардал	90,190.1	1.63
Хөдөлмөр хамгааллын зардал	209.5	0.00
Даатгалын зардал	185,853.7	3.35
Ашиглалтын зардал	3,383,910.9	60.98
Хангамжийн материалын зардал	150,312.4	2.71
Элэгдэл, хорогдлын зардал	1,199,338.4	21.61
Түрээсийн зардал	10,124.1	0.18
Тээврийн зардал	863.3	0.02
Боловсон хүчний зардал	10,912.3	0.20
Барилгын урсгал засварын зардал	176,983.8	3.19
Зардлын нийт дүн	5,549,422.9	100.00

в. Бусад зардал

Төрөл	/мянган төгрөг/	
	Өмнөх он	Тайлант он
Бусад зардал	17,775.6	99.2
Зардлын нийт дүн	17,775.6	99.2

19. САНХҮҮГИЙН БОЛОН БУСАД ЗАРДАЛ

Төрөл	/мянган төгрөг/	
	Өмнөх он	Тайлант он
Зээлийн хүүгийн зардал		2,111,575.3
Зардлын нийт дүн		2,111,575.3

20. БУСАД АШИГ/АЛДАГДАЛ

Төрөл	/мянган төгрөг/	
	Өмнөх он	Тайлант он
Бусад ашиг/алдагдал	(1,031,900.9)	-
Зардлын нийт дүн	(1,031,900.9)	-



21. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Төрөл	Өмнөх он	/мянган төгрөг/
		Тайлант он
Татварын зардал	-	(18,609.2)
Зардлын нийт дүн	-	(18,609.2)

22. НОГДОЛ АШИГ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 25/03 дугаар хурлын тогтоолоор 2024 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй талаарх шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар тогтоосон байна.

23. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

НББӨУС 24 Холбоотой талын тодруулгын дагуу холбоотой талууд гэдэг нь нэг тал нөгөө талдаа тодорхой нөлөө үзүүлэх эсвэл санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад нь нөлөөлдөг байхыг хэлнэ. УИД ХК-ийн холбоотой талд нийт 54 хуулийн этгээд болон 66.0%-ийн саналын эрхтэй зургаан Монгол улсын иргэн болон бусад хувьцаа эзэмшигчдээс бүрдэж байна. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар холбоотой талуудын ажил гүйлгээ дараах байдалтай байна.

а. Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний борлуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл

Харилцан хамааралтай этгээдийн		Ажил гүйлгээний нэр, төрөл	/мянган төгрөг/
ТТД	Нэр		Нийт дүн /өртөг/
1	2	3	4
5638771	Номин Реалтор ХХК	Түрээстэй холбоотой ажил гүйлгээ	11,038,785.6
5638771	Номин Реалтор ХХК	Бараатай холбоотой ажил гүйлгээ	300.0
НИЙТ ДҮН			11,039,085.6

б. Харилцан хамааралтай этгээдээс авсан ажил гүйлгээний худалдан авалт

Харилцан хамааралтай этгээдийн		Ажил гүйлгээний нэр, төрөл	/мянган төгрөг/
ТТД	Нэр		Нийт дүн /өртөг/
1	2	3	4
2708892	Номин Холдинг ХХК	Мэдээлэл технологийн үйлчилгээ	17,729.9
2708892	Номин Холдинг ХХК	Бусад үйлчилгээ	53,755.6
5213339	Номин Трейдинг ХХК	Бусад үйлчилгээ	330,529.6
5469929	Номин Тав Трейд ХХК	Бусад үйлчилгээ	2,403,423.7
5638772	Юнион Ойл ХХК	Бусад үйлчилгээ	264,178.4
6928064	Номин Мэйнтинэнс ХХК	Бусад үйлчилгээ	333,328.8
6788157	Номин электроникс ХХК	Бусад үйлчилгээ	289.6
6886868	Номин их дэлгүүр ХХК	Бараа бүтээдэхүүн	69,306.1
6736076	Номин хайпермаркет ХХК	Бусад үйлчилгээ	1,791.5
6891381	Номин хоумстайл ХХК	Бусад үйлчилгээ	14,728.6
5548241	Номин фүүдс ХХК	Бусад үйлчилгээ	774.1
8340927	Номинфүүдс интернационал ХХК	Бусад үйлчилгээ	905.0
5173531	Ухаалаг эрчим хүч	Бусад үйлчилгээ	

НИЙТ ДҮН	3,493,155.7
-----------------	--------------------

24. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус компанид 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайланд тусгагдсан болзошгүй өр төлбөр байхгүй. Харин санхүүгийн тайланд тайлагнагдаагүй шүүхийн шийдвэртэй авлага байна. Үүнд:

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийдвэр, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 517 дугаартай тогтоолын дагуу 2 иргэнээс тус бүр 5,884,320.6 мянган төгрөгийн авлага;

25. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайлангийн өдөр болон аудитын тайлан бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал одоогоор гараагүй болно.

